

ХАР ХОРУМ ХОТЫН ТӨВ ХЭСЭГТ ХИЙЖ БУЙ МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

ЭРНСТ ПООЛ¹, У.ЭРДЭНЭБАТ²

¹ *Institut fuer Vor-und Fruehgeschichtliche Archaeologie, Universitaet Bonn,
e-mail: pohl.yfgarch@uni-bonn.de*

² *МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологиин Тэнхим,
e-mail: u_erdenebat@yahoo.com*

Түлхүүр үгс: хот суурин, соёлт давхрага, баримтжуулалт, сууцны үлдэгдэл, халаалтын систем, гудамж, дархны газар, Монголын эзэнт гүрэн, Хар Хорум, худалдаа – гар үйлдвэрийн хороолол

Өгүүллийн товч агуулга: Монголын эртний нийслэл Хар Хорум хотын төв гудамж – худалдаа, гар үйлдвэрийн хорооллын хэсэгт 1999-2004 онд Монгол-Германы археологичдын хамтран явуулсан археологийн судалгааны үр дүнгээс энэхүү өгүүлэлд товчлон толилуулж байна. ХБНГУ-ын Бонны Их Сургуультай хамтран хэрэгжүүлсэн уг төслийн хээрийн шинжилгээний явцад хотын их гудамж, байшин барилгын зохион байгуулалтыг нарийвчлан судлахын хамт түүхийн олон үеийн турш энд хүмүүс аж төрөн сууж байсныг гэрчлэх соёлт давхрагыг илрүүлж баримтжуулжээ. Хар Хорум бол XIII-XIV зууны үеийн Монголын төр захиргааны төдийгүй худалдаа – гар үйлдвэрийн томоохон төв байсны ул мөрийг хадгалсан хэдэн зуун биет олдвор олдсоныг дурдаж, дурсгалын холбогдох он цагийг байгалийн шинжлэх ухааны аргаар нарийвчлан тогтоож, бичгийн сурвалжийн мэдээтэй харьцуулан, хотын амьдрал идэвхтэй өрнөж байсан үечлэлийг тогтоохыг оролджээ.

1254 оны хавар Францисканы санваартан Вильхельм Рубрук тэр үеийн Монголын нийслэл Хар Хорумд ирээд дундад зууны Европын хотуудтай жишихэд томоохонд тооцогдохоор барахгүй олон үндэстний шинж байдлыг хадгалсан чанараараа хол давж гарсан хоттой танилцжээ. Өгэдэй хааны үед 1235-1236 онд барилга байгууламжийн ажил өрнүүлж эхэлснээс хойш хүний нэгэн үе дөнгөж өнгөрөхтэй үгүй хугацаа болсны дараа уг хотын хэрмийн дотуур эзэнт гүрний бараг бүх ард түмний төлөөлөгчид хуран чуулж янз бүрийн ажил үйл эрхлэн, бас харилцан адилгүй нөхцөл байдлын дор аж төрөн сууж байсныг Рубрук нүдээр үзэж тэмдэглэжээ.

Тэд бүгдээр энд эрх дураараа байсангүй, ялангуяа шилдэг сайн гар урчуудын чадварыг хэрэглэх зорилгоор монголчууд хот сууриндаа тогтоон барьдаг байв. Алдартай жишээ гэвэл, Хар Хорум дахь хааны ордны мөнгөн модыг урласан франц хүн Гильом Бушье дарханыг нэрлэж болно. Гэвч Гильом Бушье болон бусад урчуудын дархны газар, урлангууд хийгээд Хар Хорумын жирийн оршин суугчдын аж байдал, амьдралын нөхцөл ямар байсан тухай бичгийн сурвалж дахь мэдээ тун

хомс юм. Өөрөөр хэлбэл, Монголын их нийслэлийн эгэл жирийн хүн амын амьдрал Рубрук болон бусад элч жуулчдын анхаарлын гадна үлджээ. Энэ нь угаас эдгээр жуулчдын аяллын гол зорилго Монголын их хаадад золгож тэдний довтолгооноос зайлсхийн гарахын тулд шашин ном дэлгэрүүлэх, улмаар монголчуудын хүч, зорилго, төлөвлөгөөг заншлан тагнахад оршиж байсантай холбоотой.

Хотын тухай өргөн хүрээтэй биш ч гэсэн Рубрукын тэмдэглэл Хар Хорумын зохион байгуулалтын тухай хамгийн дэлгэрэнгүй мэдээллийг үлдээсэн юм. Түүний онцгойлон дурдсан зүйлс гэвэл: нэг нь лалынхны орон сууц, худалдааны мухлаг байрлах сарацины хороолол, нөгөө нь катая буюу ихэнхи нь гар урчуудаас бүрдсэн хятад маягийн хороолол хоёр аж. Үүнээс гадна Рубрук өөрөө загалмайтны шашны нэгэн бүлгийн төлөөлөгч болохын хувьд Хар Хорумын шашин мөргөлийн газруудыг илүүтэй сонирхсон байдаг. Түүний бичсэнээр уг хотод несторианы нэг сүм ба түүний хүй нэгдлийн зэрэгцээ лалын хоёр дуган, бурхны шашны арван хоёр сүм зэрэгцэн оршиж хурал номын үйл ажиллагаа идэвхтэй явуулж байжээ. Мөн хот эргэн тойрон хэрмээр хүрээлэгдсэн, түүний дөрвөн талын хаалга руу чиглэсэн их зам байсан, хотын хаалга бүрт худалдааны зах талбай байрлаж байсан зэргийг тодорхой тэмдэглэжээ (Risch 1934: 256-257).

1997 онд Монгол Улсын ШУА-ийн зүгээс Германы нэрт монголч эрдэмтэн профессор Клаус Загастераар дамжуулан эртний Монголын нийслэл Хар Хорум хотын турьд Монгол-Германы хамтарсан археологийн малталт шинжилгээ явуулах хүсэлт тавьсан билээ (Huettel 2000: 40-44). Ингээд Монголын Түүхийн Хүрээлэн (2002 оны 10 сараас Археологийн хүрээлэн)-тэй хамтран ажиллах төсөл хэрэгжиж, 1999 оноос эхлэн үйл ажиллагаагаа хоёр орны ерөнхийлөгч нарын ивээл дор явуулсан юм. Тус төслийн археологийн малтлага судалгааны ажил хотын баруун өмнөд дүүрэгт орших “ордон” болон хотын төв хэмээх хоёр газар төвлөрсөн бөгөөд ордны хэсгийн малталтанд (KAR 1) ХБНГУ-ын талаас Германы Археологийн Хүрээлэнгийн Бонн дахь Комисс (Huettel 2005: 140-146), хотын төв хэсэгт хийж буй шинжилгээнд (KAR 2) Бонны Райны Фридрих Вильхельм Их Сургуулийн Өвөг ба Эртний Түүхийн Археологийн Хүрээлэн оролцсон байна (Erdenebat / Pohl 2005: 168-175).

Монгол-Германы хамтарсан экспедици археологийн малталт шинжилгээ эхлэхийн өмнө эртний хотын дэвсгэр газарт топографийн хэмжилт болон геосоронзон хайгуул хийж хэмжилтийн цэг шугамуудыг байгуулан судалгааны баримтжуулалтыг орчин үеийн түвшинд хийх эх хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэв. Хар Хорумын анхны зургийг бүр 1891 онд герман гаралтай Оросын эрдэмтэн Вильхельм Радловын удирдсан экспедици үйлдсэн билээ. Энэ шинжилгээний ангийн дорвитой бүтээлд хотын ерөнхий зургийн зэрэгцээ Эрдэнэзуу хийд болон Хар Хорумын “ордны” хэмээх хэсгийн хэсэгчилсэн зургийг нийтлэсэн байдаг (Radloff 1892). Түүний дараа 1933-1935 онд Монголын төв нутгаар археологийн шинжилгээ хийсэн Оросын судлаач Дмитрий Букинич Хар Хорумын дэвсгэрт 140 гаруй цооног малтаж, хотын дэвсгэр зургийг үйлдэн тэмдэглэсэн боловч түүний бүтээл энэ хир нийтлэгдээгүй, өдгөө Монгол Улсын ШУА-ийн Археологийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа (Букинич 1934). Дараагийн зураг 1948-1949 онд Оросын эрдэмтэн Сергей Киселев, Монголын ууган археологич Хөдөөгийн Пэрлээ нарын удирдлагаар нилээд өргөн цар хүрээтэй малталт хийж Хар Хорум судлалд үлэмж хувь нэмэр оруулсан Монгол-Зөвлөлтийн түүх угсаатны зүйн экспедицийн үйл ажиллагааны дүнд хийгджээ (Киселев 1965). Сүүлийн үеийн зураглалыг Монгол-Японы анги 1995 онд ЮНЕСКО-гийн дэмжлэгээр гүйцэтгэсэн

бөгөөд анх удаа хотын талбайд орчин үеийн топографийн хэмжилт хийж, агаарын зурагт үндэслэн хотын зохион байгуулалтыг харуулсан зураг үйлджээ (UNESCO 1996/1997). Монгол-Германы шинжилгээний анги эдгээр бүтээлүүдийг анхааран судалж, өөрсдийн явуулсан топографийн хэмжилт (Kuehn/Tisler 2000), геосоронзон хайгуулын (Mommesen /Jansen / Renner 2001: 71-77) зэрэгцээ 1970-аад оны үед авсан агаарын зурагт нарийвчилсан дүн шинжилгээ хийж Хар Хорумын ерөнхий дэвсгэр зургийг шинэчлэн боловсруулав. Энэ ажилд Германы Бонны Их Сургуулийн Цөмийн Физикийн Хүрээлэн, Карлсруэгийн Мэргэжлийн Дээд Сургуулийн Геомэдээллийн салбарын эрдэмтэд Монголын “Геомастер” компаний мэргэжил нэгт нөхөдтэй хамтран хүчин зүтгэсэн болно.

Бид хотыг судлах хүрээнд анхны малтлагын ажлаа хотын төв гудамжны уулзварын хэсэгт 1948-1949 онд Монгол, Зөвлөлтийн археологичдын судалсан “Гудамжны уулзварын байшин”-гийн малтлагын хуучин нүхний баруун урд хавьд хийхээр хэлэлцэн тогтсон юм. Тэр үед нийтлэгдсэн план зураг болон Киселевын малтлагын нүхэнд 1999 онд бидний хийсэн зүсэлтийн судалгаанаас харахад хотын энэ хэсэг суурин амьдралын илүү олон үеийн ул мөрийг агуулж байгаа нь нотлогдсон билээ. Энэхүү талбай нь 30 x 20 м хэмжээтэй бөгөөд хотын хэмжилтийн тор дээр 1070-1090 м – хойд, 750-780 м – зүүн гэсэн координатад LH 16, LH17, LH18, LH26, LH27, LH28 хэмээх өргүүдэд тохиов.

Хотын төв хэсэгт аж төрөн сууж, ажиллаж хөдөлмөрлөж байсан хүн амын сууц барилгын зэрэгцээ Хар Хорумын хойд - урд чиглэлтэй их замын үлдэгдлийг 2000 оны зунаас малтан шинжилж эхлэв. Энэхүү гудамж хоёр зуугаад жилийн турш удаа дараа засварлагдаж, хувирал өөрчлөлтийг үзэж амссан ба энд хуримтлагдсан үе давхаргуудыг судалснаар хотын барилга байгууламжийн түүхэн үечлэлийг археологийн үүднээс нарийвчлан тодруулах бололцоотой байв. Малтлагын явцад сонгож авсан талбайн хойд хэсэгт, орчин цагийн өнгөн хөрснөөс доош 2,5 метрийн гүнд модон жаазан хүрээнд суулгасан чулуу дэвсмэл их замын үлдэгдэл илрэв. 3 x 2 м орчим хэмжээтэй, тэгш өнцөгт хэлбэртэй модон хашлагаар бие биенээс тусгаарлагдсан чулуу дэвсмэл зам хоёр эгнээ бөгөөд харилцан адилгүй төвшинд гудамжны биеийг бүхэлд нь хамран үргэлжилж байжээ. Энэ нь Монгол орны хүйтэн өвөл, газар хөлдөж их зам эвдрэхээс сэргийлсэн төдийгүй гэмтэж муудсан хэсгийг тэр дор нь сольж засварлахад хялбар дөхмийг бодолцсон инженерийн нарийн шийдэлтэй бүтээл байв. Иймэрхүү бүтэц зохион байгуулалттай чулуу дэвсмэл гудамж бүр антикийн үед түгээмэл байсан бөгөөд Ромын үеийн зарим хотуудаас археологичид малтаж гаргасан байдаг.

Хар Хорумын гудамжийг байгуулахын өмнө эхлээд хайрга чулуу ба элсийг хэдэн давхар үелүүлэн дагтаршуулсны дараа сая дээр нь зам дэвссэн бөгөөд бороо цасны ус тогтож шалбааг үүсгэхгүйг бодолцож гудамжны хоёр талаар модон хашлагаар хүрээлсэн ус зайлуулах суваг үйлдсэн байв. Гудамжны энэхүү зохион байгуулалтыг хэр үргэлжилж байгааг эндээс урагш 50 метр зайтай орших LH 87/88 хэмээх өрөгт (10 x 10 м хэмжээтэй) хийсэн малталтаар шалгаж үзэхэд 20 см орчим зөрүүтэй түвшинд мөн ижил хийцтэй чулуун замын үлдэгдэл илэрсэн болно. Энэхүү чулуу дэвсмэл зам бол Хар Хорумын бидний одоогоор мэдэж буй хамгийн эртний гудамж болох нь эндээс олдсон органик гаралтай олдворуудаас дээж авч Герман Улсын Эрланген-Нюрнберг хотын Фридрих-Александр Их Сургуулийн лабораторид хийлгэсэн C¹⁴-ийн шинжилгээнээс илэрхий болов. Гудамжны хүрээ хашлаганд сайтар хатааж бэлтгэсэн маш хуучин модыг хэрэглэсэн бөгөөд хамгийн настай нь Хар Хорум хотыг байгуулсан тухай бичгийн сурвалжид заасан оноос

даруй 400 жилээр ахмад байлаа. Гэвч энэ үе давхаргад буй гудамжны чулуун хавтангуудын завсар зайд хадгалагдаж хоцорсон малын яснаас шинжилж үзэхэд их замыг байгуулсан он цаг XIII зууны эхэн хагаст холбогдох нь тодорхой болсон юм.

Монголын тал нутгийн байгаль цаг уурын онцлогоос болж байнга тохиолддог шороон шуурга, тоосжилт, түүнчлэн бороо цасны усны үйлчлэл зэргээс чулуу дэвсмэл гудамж он цагийн эрхэнд яваандаа дээр дээрээсээ элс бууригаар дарагдаж өндөрсөж иржээ. Эрт үеийн чулуун замын дээгүүр тогтсон хожуу үеийн гудамжны үе давхрагууд ч мөн харилцан адилгүй түвшинд байх бөгөөд элс хайрга, ясны хэлтэрхий, ваар савны хагархай ба бусад хатуу материалаар чигжигдэж дагтаршуулагдсан байсан. Энэ нь дээр дурдсан байгаль цаг уурын нөхцөлд Хар Хорумын чулуу дэвсмэл их зам төдий л удаан наслалгүй шороонд даруулсны зэрэгцээ Эзэнт гүрний улс төрийн төвийг урагш шилжүүлснээс хойш хотын энэ хэсэгт зам засвар, цэвэрлэгээний ажил бараг хийгдээгүй бололтойг харуулж байгаа юм. Хожуу үеийн дагтаршуулсан замыг гудамжны үүргээр ашиглагдаж байсан гэдгийг мөн түүний хоёр талаар хүрээлсэн модон хашлагатай бороо цасны ус зайлуулах сувгийн ул мөр гэрчилж байна. Энэ суваг дотор удаан хугацаанд ус урсаж, ёроолд нь элс шавар нь лагшин тунаж байсны ул мөр бидний хийсэн малталтын зүсэлтээс тодорхой харагдана. Энэ хир бидний хийсэн шинжилгээнээс үзэхэд Хар Хорумын гудамжны дээрх бүх үе давхаргууд XIII зууны эхэн хагасаас эхлээд XIV зууны сүүл хүртэлх он цагийг хамарч тухайн үеийн гар үйлдвэрчид, олон улсын худалдааны хөл хөдөлгөөнд чухал үүрэг гүйцэтгэж байжээ.

Эндхийн байшин барилгууд гудамжны нэгэн адил мөн олон удаа шинэчлэгдэж, өөрчлөн зохион байгуулагдаж байсан аж. Стратиграфийн хувьд ялгаатай хотын түүхийн өөр өөр үеүдэд хамаарах барилга байгууламжийн ажил өрнүүлж байсан ул мөрийг бид эндээс илрүүлэн судлав. Гудамжны зүүн талд ийм дөрвөн үе давхарга байгаа бол баруун талд таван ч өөр он цагийн барилгын үлдэгдэл хадгалагджээ. Байшин барилгыг цогцлон байгуулсан үндсэн материал нь шавраар хэв гарган цохиж хийсэн шатаагаагүй түүхий тоосго байсан бөгөөд барилгын цогцолборын гадна, дотно ханын хэсгүүдэд өөр өөр зарчмаар өрлөгийн ажлыг үйлдсэн байв. Шатааж боловсруулсан тоосго бидний судалсан хэсэгт маш цөөн тохиолдсон бөгөөд зөвхөн онцгой зарим тохиолдолд хэрэглэж байсан бололтой.

Хар Хорумын хотын төв хэсгийн хамгийн эрт үед хамаарах барилгууд XIII зууны эхэн хагаст хамаарах бөгөөд дүнзээр зангидаж хийсэн яс модон жаазанд түүхий тоосго эгнүүлэн өрж банзаар бэхэлсэн зохион байгуулалттай байв. Ингэж хийснээр барилгын хана туурга харьцангуй нимгэн хэдий ч дээвэр нуруугаа тулах хангалттай хэмжээний даацыг агуулж чадаж байжээ. Дундад зууны Европын иймэрхүү хийцтэй барилгуудаас Хар Хорумд бидний судалсан барилгуудын ялгагдах онцлог тал нь модон хийцүүд ханын гадна ил харагдахгүй, харин дотуур бэхэлгээ маягтай далд хийгдсэн явдал юм.

Хожуу үеийн барилгын үед хамаарах хана туурганы үлдэгдлийг судлахад модон бэхэлгээгүй дан түүхий тоосгоор өрсөн барилга голлож байлаа. XIII зууны эхэн хагаст бидний хамааруулсан эрт үеийн барилгын үлдэгдэлтэй харьцуулахад XIV зууны үеийн барилга байгууламжид хэрэглэсэн үндсэн материал нь ерөөс дан түүхий тоосго болж хувирсан байв. Байшингийн гадуурх хана туургыг түүхий тоосгоор хайрцаглан өрж, элдэв хэлбэр гарган цогцлон бүтээсэн бөгөөд зарим ханыг шавардаж шохойдон дээр нь зураг зурж чимэглэдэг байжээ. Хэдийгээр бид өдгөө нэг ч барилгыг бүтэн талбайгаар нь малтан судлаагүй байгаа боловч гудамжны хоёр

талаар ерөнхийдөө хятад маягийн архитектуртай байшингууд байсан гэж таамаглаж болно. Учир нь юуны өмнө эндээс шавраар шатааж хийсэн, саарал өнгийн голдуу дээврийн ваарны янз бүрийн хэсгүүд, хятад маягийн барилгын дээврийг чимэглэхэд хэрэглэдэг төрөл бүрийн барилгын чимэглэлийн хэсгүүд илэрч гарсны зэрэгцээ барилга төлөвлөлтийг хийхдээ гол дунд нь сул талбай үлдээж түүнийг тойрсон жижиг барилгуудыг зэрэгцүүлэн хэрэм хашаа мэт хүрээлж барьдаг хятад архитектурын онцлогийг тусгасан нь харагдаж байсан.

Барилгын доторхи өрөө тасалгаануудыг мөн түүхий тоосгоор өрсөн хана тусгаарлаж байв. Түүнээс гадна энд танхим маягийн томоохон тасалгаа ч илэрсэн бөгөөд тийм том өрөөний дээврийг тулж байсан модон баганы үлдэгдлүүд, доор нь ивсэн засмал чулуун суурийн хамт илэрч гарсан ба зарим тохиолдолд баганыг газар ухаж суулгасан нүхний ул мөр үлдсэнийг бид баримтжуулсан билээ.

Хотын төв хэсгийн барилгуудын шалны түвшинд зуухнаас гарсан халуун уураар байшин савыг дулаацуулж байсан халаалтын системийн үлдэгдэл энд тэндгүй илрэв. Зарим ханзны сувгийг түүхий тоосгыг нимгэн талаар нь зэрэгцүүлэн өрж дээрээс нь хавтгай чулуугаар тагласан байх бөгөөд урт удаан хугацаанд галлаж халуун утаа гүйлгэж байснаас дотор тал нь хөө исэнд баригдаж бараг шатаагдсан байв.

Барилгын шалыг шавар дагтаршуулан хийх нь тэр үед нэн түгээмэл байсан ба зарим өрөө тасалгааг модон банзаар шаллаж, дээгүүр нь сүрлэн дэвсгэр юмуу хивс дэвсэж байсан ул мөр ажиглагдсан. Шалан халаалтын зэрэгцээ мөн ижил зарчмаар дороосоо дулаацах ханзан орны сайн хадгалагдсан үлдэгдэл ч илэрсэн билээ. Эдгээрийг түүхий тоосгоор гурваас дөрөв давхарлан өрж хийснээс үзэхэд хэвтэх юм уу суух зориулалттай байсан бололтой. Түүний зэрэгцээ байшин дотор хүйтэн цагт нүүрсний цог цучил тавьж орон гэрээ дулаацуулдаг ширмэн хоовон савнууд бүрэн бүтнээрээ тохиолдов.

Хотын төв хэсэгт явуулж буй судалгаагаар илэрсэн олдвор ба зохион байгуулалтын байдлаас ажиглахад бид энд Хар Хорумын худалдаа – гар үйлдвэрийн хорооллын нэгэн хэсгийг малтаж байгаа юм байна гэдгээ түвэггүй ойлгож болохоор байв. Бид эндээс янз бүрийн материалыг боловсруулж байсан бүхэл бүтэн зуух ба голомтны ор үлдэгдлүүдийг олноор малтаж гаргасан. Ихэнх зуухнууд зөвхөн хавтгай тэнхлэг дээр ором төдий мэдэгдэж байсан боловч бид эндээс бас бөмбөгөр оройтой харьцангуй сайн хадгалагдсан зуухнуудыг ч тэнд хайлуулж байсан шил, төмрийн баасны үлдэгдлийнх нь хамт олсон юм. Эдгээр зуухнууд 50-80 см орчим голчтой, бөмбөгөр хэлбэртэй зуухны галын хөндий нь 1 м хүртэл өндөр, ханыг нь мөн л шатаагаагүй түүхий тоосгоор үйлдсэн эгэл хийцтэй байв.

Энд амьдарч байсан хүн амын гар үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тэдний үлдэж хоцроосон эд өлгийн биет зүйлүүдээс үндэслэн маш өргөн хүрээтэй байсан гэж баттай хэлж болно. Жишээлбэл, металл эд зүйл урлаж хийж байсан хоорондоо цаг хугацааны хувьд ялгаатай хоёр дархны газар энд оршин тогтнож байжээ. Гудамжны зүүн талд хотын илүү эртний үед хамаарах дархны нэгэн газар байсан бөгөөд зэс, хүрлээр юм хийж байсан нь илэрхий. 2004 оны малталтаар эндхийн гудамжны зэрэгцээх барилгын буурин дотор сайн хадгалагдсан 30-40 см голчтой, 80 см орчим өндөр модон тайрдсаар хийсэн хэд хэдэн суурь илэрсэн бөгөөд голд нь металлаар хийсэн дөш суулгаж юм балбаж дархалж байсны ул мөр дөрвөлжин хэлбэртэй дөшний ором, модон суурь ба түүний ойр орчим нэлэнхүйдээ хүрлийн үйрмэг, хайчилж огтолсон хаягдал зэсээр хучигдсан нь илэрч гарсан билээ. Түүний

зэрэгцээ зэс хүрэл хөөлгөн цохиж элдэв эдлэл хийхэд ашиглаж байсан хэв, арьс шир ба даавууны тасархай ч нилээд байлцав.

Хар Хорумын төмөрлөг эдлэлийн уран дархны ажил хотын түүхийн хожуу үе буюу XIV зууны сүүлчээр мөн саараагүй болохыг бидний олдворууд гэрчилж байна. Гудамжны орчмын барилгын үлдэгдлээс энд сууж байсан дархчуудын бүтээлүүд өдий төдийгөөр олдov. Ганц жишээ дурдахад, тодорхойгүй шалтгааны улмаас дуусгалгүй орхисон нэг алтан бугуйвч, мөн түүнийг бүтээсэн эх загварын хамт олдсон нь тун ховор тохиолдол билээ. Бугуйвчин дээр Сасанидын Иранаас гаралтай домгийн шувуу, Зүүн Азийн урлагийн нүүр царай болсон амьтны нүүр зээ бaдын дүрсийг уран чадварлаг үзүүлсэн нь Хар Хорумын дархны урлагийн газар газрын сайчуудын охь дээжийг хослуулсан чадварын төвшинг илтгэнэ. Түүнчлэн, эндээс хэв цутгах халбага, алт мөнгөний сорьц шалгадаг чулуу, үнэт эдлэлийн дархны чухал хэрэглэгдэхүүн болох мөнгөн ус шаазан савтайгаа хүртэл олдсон нь сонирхолтой юм.

Бидний судалж буй хэсэгт мөн төмрийн дархны урлал цэцэглэн хөгжиж байжээ. Гудамжны баруун талын барилгын хэсэгт төмрийн дархны урлалын агуулах илэрсэн. Эндээс модон булд нь шигтгэж дугуйны эргэлтийг сайжруулахад чухал үүрэгтэй тэрэгний нэгэн эд анги болох ширмэн цөнгүүд, түүнчлэн төмрөөр хийсэн төрөл бүрийн багаж зэвсэг, хутга шөвөг, шанага хүрэнээс өгсүүлээд анжис сүх тэргүүтэнг малтаж гаргав. Төмөрлөг эдлэлийн зэрэгцээ Хар Хорумын төвд шил ба үнэт чулуу боловсруулах, ялангуяа ясаар төрөл бүрийн багаж зэвсэг, гоёл чимэглэлийн зүйл хийх, үйсээр ахуйн хэрэгцээний олон янзын эдлэл хийх үйлдвэрлэлийн ул мөр биетээр тодорхойлогдов.

Вильхельм Рубрукын тэмдэглэсэнчлэн Хар Хорумын худалдаа гар үйлдвэрийн хороололд Катай буюу олзны хятад гар урчууд амьдран сууж, хотын аж ахуйн үйл ажиллагаанд чухал үүрэгтэй оролцож байсны ул мөр бидний явуулсан шинжилгээнээс ч тод томруун харагдсан. Юуны өмнө энд керамик олдворуудыг онцлон дурдах ёстой. Хятадын керамикийн технологийн уламжлалыг хадгалсан олон мянган ваар, шаазангийн хагархай малтлагын бараг бүх үе давхаргаас гарлаа. Эдгээрийн ихэнх нь хагарч цуурсан боловч заримыг нь бас сэргээн эвлүүлж хэлбэр дүрсийг нь тодорхой мэдэж болохоор. Хятадын алдарт хөх хуартай чин-хуа, ногоон өнгөт селадон лун-цзюань, рү хийгээд гоёмсог хөх өнгийн паалант цзюнь, шувууны өд мэт судалтай жио-тай, төмрийн зэвний хольцтой цзяо ба цагаан шаргал өнгийн дин, уран чамин угалз хээтэй цзычжоу, ю-ли-хун зэрэг шаазангийн олон төрлийн зэрэгцээ лалын урлагийн өнгө төрхийг илтгэсэн сав суулгын үлдэгдлүүд ч нилээд олдov. Эдгээрээс гадна орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн сайн шатааж хийсэн, хар саарал өнгийн шавар сав суулга олон төрөл зүйлээр тохиолдож байсан.

Хар Хорумд Дундад Ази, Хятадаас бараа тээвэрлэн авчирч хөлтэй худалдаа хийж байсны гэрч болох импортын бараа бүтээгдэхүүн хүрэл толь, шаазан эдлэл, наймаачдын хэрэглэж байсан жингийн туухай, гүйлгээнд ашиглаж байсан гуулин ба мөнгөн зоос хэдэн арваараа олдov. Хар Хорумын зооснууд он цагийн хувьд өөр өөр бөгөөд ерөнхийдөө Тан улсаас Юан улсын үеийг хамарна. Гурван зуу гаруй зоосны дийлэнх нь хятад үсэгтэй, цөөвтөр нь монгол дөрвөлжин үсэгтэй гуулин зоос байсан ба араб үсэгтэй мөнгөн зоос нийт есөн ширхэг гарчээ. Европ гаралтай эд өлгийн зүйлс одоогоор илрээгүй бөгөөд стратиграфийн үйл явцыг дүгнэж үзэхэд Хар Хорумаас гарах бүрэн магадлалтай. Үүнээс гадна олдворын зонхилох хэсгийг төмөр хадаас, хүрэл эдлэлийн өөдөс, шилэн ба чулуун сувс зүүлт, зассан ба дутуу зассан

ясан эдлэлүүд, дорно дахины орнуудад ихэд түгэн дэлгэрсэн нэгэн зүйл шатар “го” хэмээх хөлөгт тоглоомын чулуу эзлэж байв.

Түүнчлэн бидний хийж буй археологийн шинжилгээ нь Хар Хорум хотын түүхэнд холбогдох сурвалжийн мэдээг эртний судлалын үр дүнд олдсон бичиг үсгийн холбогдолт биет баримтаар анх удаа баталгаажуулж байгаагаараа Монголын түүх судлалд хувь нэмэр оруулж буйг энд онцлон дурдахад таатай байна. 1368 онд Юан гүрэн мөхөж монголчууд Хятадаас эх нутагтаа буцан ирж дахин Хар Хорумдаа нийслэллэн суусны бодит гэрч болох 1371 онд Билэгт хаан цолтой Орхоны хөндийн хуучин хотод их ор суусан Аюуширидарагийн Сангийн Яамны сайдын эрхэлсэн түшмэлийн барьж байсан дөрвөлжин ба хятад үсэгт нэгэн тамга 2001 онд бидний хийсэн шинжилгээгээр олдсон юм (Weiers 2002). Мөн 2004 оны малталт судалгааны явцад 1237-1238 онд Өгэдэй хааны үед цутгасан “Хар Хорум” гэсэн араб бичээстэй мөнгөн зоосыг илрүүлэн олсон нь одоогоор Монголын эртний нийслэлийн нэрийг бичсэн хамгийн эртний бичгийн дурсгал болж байна (Heidemann /Kelzenberg /Erdenebat /Pohl 2005, 93-102).

Хар Хорумын археологийн малталт шинжилгээний явцад тусгай боловсруулсан аргагүйн дагуу хөрснөөс дээж авч тухайн үеийн орчин тойрныг сэргээх оролдлогыг Германы Баден-Вюртемберг мужийн хөшөө дурсгалыг хамгаалах албаны ажилтан доктор М. Рөшийн удирлагаар хийж гүйцэтгэсэн нь сонирхолтой урьдчилсан үр дүнд хүргэв (Roesch/ Fischer/ Maerkle 2005). Палеоботаникчид Хар Хорумын эртний хөрсний дээжийг шинжилж нийтдээ 50 000 орчим ургамлын үлдэгдлийг илрүүлэн олсон нь тухайн үеийн Европын хотуудынхаас огт дутахааргүй байв.

Монголчуудын эртний хоол хүнсний тухай мэдээ хомс, ялангуяа тэдний ургамлын гаралтай хоол тэжээлийн тухай ойлголт маш бүрхэг, тэгээд ч ихэнх хүмүүс монголчуудыг дандаа мах иддэг, таримал ургамал огт хэрэглэж байгаагүй бөгөөд сайндаа л малынхаа сүү саалийг боловсруулж цагаан идээ хэрэглэхээс хэтэрдэггүй байсан гэж боддог байлаа. Үнэхээр ч бидний явуулсан малтлагын бүх давхаргаас мал, амьтны яс асар их гарсны ихэнхийг тэнд байсан хүмүүс хоол хүнсэндээ хэрэглэсэн гэж үзэж болохоор байв. Гэтэл хотын төв гудамжны уулзварын өмнөд хэсэгт малтсан талбайгаас Хар Хорумын хүн амын хоол хүнсэндээ хэрэглэж байсан үр тарианы 5 зүйлийг ургамал судлаач эрдэмтэд тодорхойлж чадав. Эдгээр нь нүцгэн улаан буудай, хивэг багатай арвай, овъёос, аму буюу шар будаа, хивэг ихтэй улаан буудайн өөр нэгэн зүйл болох бөгөөд цөм хавар тариалж намар хурааж авдаг зуны сортууд байжээ. Энд зуны тариа тарьдаг байснаас үзвэл монголчууд ойр хавийн ижил цаг уурын нөхцөлтэй газраас үр авч байсан бололтой. Бас овъёосны хальс ба цэвэрлэсэн үлдцийг олсон нь уг ургамлыг энд Хар Хорумд тариалж бас цэвэрлэж боловсруулж байсны нэгэн гэрч юм. Бас тосны ургамал, маалинга, вандуй, таримал шошны зэрэгцээ жимсны зүйлээс хушны самар, алимны үр, хамгийн элбэг нь дарсны усан үзмийн үр олджээ. Чингис хаан болон түүний удмынхан энэ хавиар усан үзэм тарьж байсангүй, учир нь Монгол нутгийн өвөл тэсгим хүйтэн тул усан үзэм их тарьдаг Дундад Азийн Самарканд зэрэг газраас авчирч хатаах ба шинээр нь идэхээс гадна дарс эсгэж хааны ордонд байсан алдарт мөнгөн модноосоо гоожуулж байсан болов уу. Түүнээс гадна сорьцонд ихээр тааралдсан зүйл нь загасны хайрс, яс байгаа зэргээс үзэхэд тухайн үеийн Хар Хорумын оршин суугчид мал амьтны гаралтай бүтээгдэхүүний зэрэгцээ гурил будаа, жимс ногоо, загасыг хүртэл хоол хүнсэндээ өргөн хэрэглэж байсан нь тодорхой ажээ.

Бид малтан шинжилсэн бүх үе давхаргаас тодорхой тооны дээж авч орчин үеийн байгалийн шинжлэх ухааны нарийн судалгаагаар хотын түүхэн болон археологийн үечлэлийг улам тодруулан харах бололцоотой болов. Хар Хорумын барилга байгууламжийн эхний үе шат XIII зууны эхэн хагаст, Өгэдэй хааны эрин үед явагдсан нь археологийн үүднээс магадлагдсаны дээр хотын төв гудамжны уулзварын өмнөх хэсэг эхнээсээ их гудамж ба түүний хоёр талаар суух гар урчууд, худалдаачдын орон сууц, дархны газар, урлан хийгээд дэлгүүр мухлаг байрлахаар төлөвлөгдсөн бололтой. Бидний малтсан хэсгийг бүхэлд нь хамарсан гал түймэр ба сүйтгэж эвдэлснийг батлах ул мөр илэрсэнгүй. Энд зам ба байшин барилгын өөр өөр үед хамаарах 4-5 үе давхарга дээр дээрээсээ давхарлан оршиж байх бөгөөд XIV зууны сүүл хүртэл хотын амьдрал нэн идэвхтэй өрнөж байжээ. Хотын түүхийн хожуу үед хамаарах баталгаат олдвор- тамганы бичээсээс үзэхэд 1370 онд Инчан хотод насан эцэслэсэн Тогоонтөмөр хааны хөвгүүн Аюуширидар 1371 онд Хар Хорумаар төвлөсөн Умард Юан улсыг байгуулж оны цолыг Юан гүрний уламжлалаар “сюангуан” хэмээн нэрийдэж 1378 оны 5 сар хүртэл сууж байсан тэр нэгэн зурвас үе хотын энэхэн хэсэгт нэн тод ул мөрөө үлдээжээ. Мин улсын түрэмгий цэрэг 1380/1388 онуудад Орхон гол хүртэл давшиж үзэсгэлэнт сайхан Хар Хорум хотыг галдан шатааж Монголын соёлд нөхөж баршгүй хохирол учруулснаас хойш энд ерөөс удаан суугаагүй зайлсан болохыг ч археологийн судалгааны биет олдворууд нотлон харуулав. Түүнчлэн энэ үед огт төлөвлөөгүй байдлаар дээр өгүүлсэн дархны газар, орон байр, худалдааны мухлаг саваа хүмүүс орхиж явснаар Хар Хорумын гар үйлдвэр, худалдааны цэцэглэлт бүрэн төгсгөл болжээ хэмээн одоогоор хэлж болохоор байна.

НОМ ЗҮЙ

- Букинич Д. Д.*, 1934. Общий отчет по археологическим работам за 1933 и 1934 год. Рукописный фонд Института Археологии Академии Наук Монголии, Улан-Батор.
- Киселев, С.В.*, 1965. Древнемонгольские города. Москва.
- Erdenebat U., Pohl E.*, 2005. Aus der Mitte der Hauptstadt – Die Ausgrabungen der Univeritaet Bonn im Zentrum von Karakorum. In: Dschingis Khan und seine Erben. Das Weltreich der Mongolen. Bonn/Muenchen, 168-175.
- Heidemann S., Kelzenberg H., Erdenebat U., Pohl E.*, 2005. The first Documentary Evidence for Qara Qorum from the year 635/1237-8. In: Zeitschrift fuer Archaeologie Ausereuropaeischer Kulturen 1, 93-102.
- Huettel H.-G.*, 2000. Das Zerbrochene Bergen. Die Mongolisch Deutsche Karakorum Expedition. In: Mongolische Notizen. Bd. 9, Bonn, 40-44.
- Huettel H.-G.*, 2005. Der Palast des Ogedei Khan – Die Ausgrabungen des Deutschen Archaeologischen Instituts im Palastbezirk von Karakorum. In: Dschingis Khan und seine Erben. Das Weltreich der Mongolen. Bonn/Muenchen, 140-146.
- Kuehn S., Tisler M.*, 2000. Erstellung eines Digitalen Gelaendemodells im Gebiet von Karakorum (Mongolei) durch topographische Gelaendeaufnahme sowie analytische und digitale Luftbildauswertung. Diplomarbeit der Fachhochschule Karlsruhe Fachbereich Geoinformationswesen Studiengang Vermessungswesen. Karlsruhe.
- Mommsen H., Jansen F., Renner R.*, 2001. Geomagnetische Prospektionsmessungen in Karakorum, Mongolei. In: Archaeologisches Zellwerk. Beitrage zur Kulturgeschichte in Europa und Asien. Festschrift fuer H. Roth zum 60. Geburtstag. hrsg. von E. Pohl., Internationale Archaeologie: Studia honoraria, Rahden/Westf., Leidorf, 71-77.
- Radloff W.*, 1892. Atlas der Alterthuemer der Mongolei. Sankt Petersburg.
- Risch F.*, 1934. Wilhelm von Rubruk. Reise zu den Mongolen 1253-1255. Leipzig.

- Roesch M., Fischer E., Maerke T.*, 2005. Human diet and land use in the time of the Khans – Archaeobotanical research in the capital of the Mongolian Empire, Qara Qorum, Mongolia. In: Vegetation History and Archaeobotany 14, 2005 (Tagungsband IWGP – Tagung Girona 2004).
- UNESCO*, 1996/97. Mongolia's Tentative List Cultural and Natural Heritage. UNESCO Beijing Office, Ministry of Enlightenment Mongolia. Beijing / The Ancient City of Kharakhorum. The Mongolian Ministry of Education, Science and Culture and United Nations Educational, Scientific and Cultural Organization. Drafted by Prof. Shimpei Kato of Kokugakuin University, Beijing.
- Weiers M.*, 2002. Die Siegel des Ayuširidara, die politischen Ideologien der Mongolen, und ihre Geschichtsschreibung. In: *Stipes philologiae Asiae maioris* 04.

SUMMARY

E.Pohl, U.Erdenebat

MONGOLIAN-GERMAN JOINT ARCHAEOLOGICAL RESEARCH IN THE CENTRAL PART OF QARA QORUM

In 1999-2004 the Mongolian-German Karakorum Expedition (the Institute of Prehistoric and Early Historic Archaeology, the University of Bonn and Institute of Archaeology, the Mongolian Academy of Sciences) has conducted excavations in the central part of Qara Qorum, former capital city of Mongolian Empire. In this article we present some results of the research. During excavations, many different cultural layers, ruins of buildings and walls, street with stone plaster, floor, heating system and water canalization were discovered. Many parts of the ancient city were never excavated before in Mongolia, thus the excavation plays significant role in the understanding of sedentary life of medieval Mongolian nomads.